



# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн  
нийгэм, эдийн засгийн  
танилцуулга

## ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

### 2018/9



Мэдээллийн нэгдсэн лавлах: [WWW.1212.MN](http://WWW.1212.MN)

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

(2018 оны 09 дүгээр сарын байдлаар)

**Нэг. Нийгмийн үзүүлэлт****1.1 Хүн ам**

Дорноговь аймгийн хэмжээнд 2018 оны 09 сард 1034 эх амаржиж, 1037 хүүхэд шинээр мэндэлжээ. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 86(9.1%)-аар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 83(8.7%)-аар, 298 хүн нас барсан нь 44(17.3%)-өөр тус тус өссөн байна.

Хүн амын цэвэр өсөлт 739 болж өмнөх оны мөн үеэс 39(5.6%)-өөр өсчээ. 1000 хүнд ногдох төрөлт 15.4, нас баралт 4.4 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.7 пунктээр, нас баралт 0.5 пунктээр тус тус өслөө.

*Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2015-2018 оны 09 сард*



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд нялхсын эндэгдэл 13 байгаа нь өмнөх оны мөн үеэс 4-өөр их байна.

**1.2 Эрүүл мэнд**


2018 оны 09 сарын байдлаар 263.4 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар, 12.5 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар тус тус өсч, 8.4 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар буурсан байна.

2018 оны эхний 09 сард 1207 эх жирэмсний хяналтанд орсны 88.0 хувь буюу 1062 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 14.8 мянган удаа гарсны 2.5 мянга буюу 16.9 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 6.5 хувиар, алсын дуудлага 4.2 хувиар тус тус өсчээ.

Он гарсаар ослын улмаас 2406 хүн бэртэж, 76 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 361(17.7%)-ээр, нас барсан хүний тоо 14(22.6%)-өөр тус тус нэмэгдсэн байна.

*Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2018 оны 09 сард*



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд осол гэмтэл, хордлого гадны шалтгаант нас баралт 25.5 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 24.2 хувь, хавдар 19.1 хувь, бусад төрлийн өвчин 14.1 хувь, хоол шингээх эрхтний тогтолцооны өвчин 10.7 хувь, амьсгалын тогтолцооны өвчин 6.4 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 533 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 33(5.8%)-аар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад вирус гепатит 12.5 хувь, бусад төрлийн өвчин 58.4 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.

### 1.3 Соёл, боловсрол

Аймгийн соёл урлагын байгууллагууд эхний 9 сарын байдлаар 30.4 мянган хүнд үйлчилж, 27.0 сая төгрөгийн орлоготой ажиллажээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн урлагийн байгууллага 138 удаагийн тоглолт хийж, музейнүүд дотоод, гадаадын 3.5 мянган хүнд үйлчилсэн байна.




#### 1.4 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2018 оны 09 сарын эцэст 965 болсны 915 (94.8%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 50 (5.2%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 590 (37.9 %) хүнээр буурч, өмнөх сараас 231(31.5%) хүнээр өссөн байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 468 (48.5%) нь эмэгтэйчүүд бөгөөд 526 (54.5%) нь Сайншанд суманд, 143 (14.8%) нь Замын-Үүд суманд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 64.7 хувь нь бүрэн дунд, 16.7 хувь нь дээд, 6.6 хувь нь техник болон мэргэжлийн, 5.1 хувь нь бүрэн бус дунд, 3.4 хувь нь тусгай дунд, 2.5 хувь нь боловсролгүй, 0.8 хувь нь бага, 0.2 хувь нь магистр/докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2018 оны 09-р сард



Хөдөлмөрийн хэлтэст он гарсаар 2201 иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 443 иргэн ажилд зуучлагдан орж, 200 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна

Ажлын байрны захиалга 539 бүртгэгдсэний 194 (35.9%) нь уул уурхайн олборлох аж үйлдвэр, 83 (15.4%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 57 (10.6%) нь төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 30 (5.6%) хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээний салбарт байна. Ажил хайгч 443 иргэн хөдөлмөрийн байгууллагаар дамжуулан ажилд зуучлуулан орсны 195 (44.0%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг. Бүртгээгүй ажилгүй иргэд сумаар



Зураг. Шинээр ажлын байранд орсон иргэд салбараар



### 1.5 Нийгмийн даатгал, халамж

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 09 сард 23799.1 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3324.8 (16.2%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны эхний 09 сард өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар нэмэгдэхэд тэтгэврийн даатгал 2727.4 (22.3%) сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сан 455.6 (22.5%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 310.0 (22.3%) сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2018 оны 09 сард





Нийгмийн даатгалын сангийн зарлага 33303.6 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 4158.7 (14.3%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 24203.9 (72.7%) сая.төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4809.7 (14.4%) сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас 1873.6 (5.6%) сая.төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1813.4 (5.4%) сая.төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 603.0 (1.8%) сая төгрөгийг зарцуулжээ.


Зураг. Нийгмийн даатгалын зарлага, сая төг




Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээгээр 2018 оны эхний 09 сард нийгмийн халамжийн сангаас 22998 иргэнд 6069.9 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 5422 (30.8%)-өөр, олгосон тэтгэвэр тэтгэмж 1571.8 (34.9%) сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж өсөхөд насны хишиг, цалинтай ээж хөтөлбөрт 6147(26.7%) иргэн хамрагдаж, 1719.8(28.3%) сая төгрөгийн тэтгэмж олгосон нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2018 онд 1362 хүн хамрагдсан нь өмнөх оноос 11 (1.0%) хүнээр буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 82.7 (5.1%) сая төгрөгөөр нэмэгджээ. Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжид 1069 иргэнд 568.7 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 996 иргэнд 466.1 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 8386 иргэнд хамруулж 823.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн бусад халамжийн шаардлагатай иргэнд үзүүлэх тусламжийг 11185 иргэнд 2508.8 сая төгрөг олгосон байна.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /мян төг/



## 1.6 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 9 сарын байдлаар 396 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 94 хүн гэмтэж, 16 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 138(25.8%)-аар, гэмтсэн хүний тоо 76(44.7%) –аар, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо өмнө оны мөн үеэс 7(30.4%) –оор буурсан байна.




Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 54(23.9%)-өөр, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 28 (21.7%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 23(53.5%)-аар, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 17(68.0%)-аар, хүний амины гэмт хэрэг 14(73.7%)-өөр, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 3(37.5%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1(6.7%)-ээр буурч, авилгын гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 172(43.4%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 101(25.5%) нь хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 40(10.1%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 58 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 75(56.4%) -аар буурсан байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Иххэт, Өргөн, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 708.1 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3394.8(82.7) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 415.6(58.7%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 105(26.7%) нь гэр сууцандаа, 56(14.1%) нь гудамж, талбайд, 58(14.6%) нь согтуугаар, 17(4.3%) бүлэглэн, 54(13.6%) хувийг эмэгтэй хүн оролцон, 133(33.6%) нь шөнийн цагаар /22.00-06.00 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 1001 хүн эрүүлжүүлэгдэж, 209 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 09 сард




### Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




#### 2.1 Мөнгө, зээл

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 1057.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 201.7(23.6%) тэрбум төгрөгөөр өсч, цэвэр зарлага 1000.3 тэрбум төгрөг болж 184.7(22.7%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2017- 2018 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2017-2018 он, сая.төг




Иргэдийн мөнгөн хадгаламж 93.9 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1353.5 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 1377.3 мянган төгрөгийн

хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 3.0(4.5%) мянган хүнээр, хадгаламжийн үлдэгдэл 18.9(25.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2018 оны 09 дүгээр сарын эцэст 3946.1 сая төгрөг болж, өмнөх сараас 497.8(14.4%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 1456.3(58.5%) сая төгрөгөөр нэмэгджээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.6 хувийг эзэлж, өмнөх сараас 0.2 пунктээр, өмнөх оны мөн үеэс 0.4 пунктээр нэмэгджээ.


Чанаргүй зээл 09 дүгээр сарын эцэст 7365.0 сая төгрөг болж өмнөх сараас 925.8(11.2%) сая төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 772.0(9.5%) сая төгрөгөөр буурсан. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр буурсан байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2018.09 сард



Зураг.

Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2018.09 сард



## 2.2 Орон нутгийн төсөв

2018 оны 09 дүгээр сарын байдлаар орон нутгийн төсөвт 20061.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 101.8 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 20.3 хувиар өссөн байна. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 75.9 хувийг татварын, 24.1 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2018 оны 09-р сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр нийт 3806.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 933.2(32.5%) сая.төг-өөр нэмэгдэж, тухайн оны төлөвлөгөөнөөс 1560.7(69.5%) сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



### 2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.


Хэрэглээний үнийн индекс 2018 оны 09 дүгээр сарыг өмнөх сартай харьцуулахад адил, харин өмнөх оны мөн үеэс 4.7 хувиар өсчээ.

**Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өсөхөд:** хүнсний бараа, ундаа усны бүлэг 4.9 хувь, согтууруулах ундаа, тамхи 4.3 хувь, хувцас бөс бараа, гутал 2.5 хувь, орон сууц, ус, цахилааны, түлшний бүлэг 1.0 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 1.6 хувь, эм, тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 22.6 хувь, тээвэр 6.7 хувь, амралт чөлөөт цаг соёлын бараа 6.2 хувь, боловсролын үйлчилгээ 9.9 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 3.9 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлэг 2.8 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 09 дүгээр сарын өөрчлөлт, өмнөх оны мөн үетэй харьцуулсанаар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2018 оны 09 дугаар сарын өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)




Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт



### 3.1 Хөдөө аж ахуй

Оны эхний 09 сарын байдлаар төллөвөл зохих эх малын 72.9 хувь буюу 617.4 мянган толгой мал төллөж, төл бойжилт 97.4 хувьтай байна. Өмнөх оны мөн үеийнхээс төллөсөн хээлтэгч 31.6(5.4%) мянган толгойгоор, төл бойжилт 17.5(2.9%) мянган толгойгоор илүү юм.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, толгой



Эхний 9-н сарын байдлаар 10291 том мал хорогдож өмнө оны мөн үеэс хорогдол 8.1(4.6 дахин) мянган толгойгоор нэмэгдсэн байна. Хорогдол нэмэгдэхэд Дэлгэрэх, Иххэт сумдын нутаг дэвсгэрээр 4-р сард нойтон цас орж, хүчтэй цасан шуурга шуурч байгалийн онц аюултай үзэгдэл болж, Дэлгэрэх суманд 2.2 мянган толгой мал, Иххэт суманд 2.2 мянган толгой мал, Даланжаргалан суманд 1.2 мянган толгой мал хорогдсон нь голлон нөлөөлсөн байна.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн судалгаагаар Сайншанд суманд 09-р сард ноолуурын дундаж үнэ 50000 төгрөг болж өмнөх оны мөн үеэс 5000 (23.1%) төг-өөр буурсан байна. Харин үхэрийн шир 6.0 мянган төгрөг, адууны шир 6.0 мянган төгрөг, ямааны арьс 3.0 мянган төгрөгийн ханштай байна. Эр хонь 100.0-180.0 мянган төгрөг, эр ямаа 60.0-150.0 мянган төгрөг, хязаалан шар 600.0-1300.0 мянган төгрөг, соёолон үрээ 450.0-1200.0 мянган төгрөгөөр худалдаалагдаж байна.



### 3.2 Аж үйлдвэр

Оны эхний 09 сард аж үйлдвэрийн салбарт 159948.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 231302.1 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 44.4 хувиар, борлуулалт 31.9 хувиар тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 2.8 хувийг төрийн, 97.2 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 2.8 хувь, компани 96.9 хувь, өрхийн аж ахуй 0.3 хувийг тус тус эзэлж байна.


Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дулаан 3.3 мян.ккалаар, ус түгээлт 93.1 мян.м3-ээр, сувагжуулалт 88.2 мян.м3-ээр, нарийн боов 20.2 тонноор, бялуу 0.4 тонноор, сүүн бүтээгдэхүүн 1.3 мян.литрээр, нүүрс 126.7 мян.тонноор, вакуум цонх 1237.9 м2-аар, цемент 259.3 мян.тонноор, модон эдлэл 22947.9 мян.төгрөгөөр, жижиг оёдол 7744.8 мян.төгрөгөөр тус тус илүү үйлдвэрлэгджээ



### 3.3 Барилга угсралт, их засвар

2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 348185.5 сая төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 4.0 дахин нэмэгдсэн байна. Барилгын нийт хөрөнгө оруулалтын 0.8 хувийг улсын төсвийн, 0.9 хувийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, үлдэх хувийг хөрөнгө оруулалтын бусад эх үүсвэрээр санхүүжүүлжээ.

**Зураг. Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, мян төг**



Барилга угсралт их засварын ажлын 83.0 хувь нь инженерийн барилга, байгууламж, 11.4 хувь нь орон сууцны бус барилга, 4.7 хувь нь орон сууцны барилга, 0.9 хувь нь их засварын ажил байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны бус барилгынх 39.1 пунктээр, орон



сууцны барилгын эзлэх хувь 36.9 пункт, их засварын ажлынх 5.0 пунктээр буурч, инженерийн барилга, байгууламжийн эзлэх хувь 81.1 пунктээр өссөн байна.

## Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



### 4.1 Байгаль орчин Цаг уур

2018 оны 09 дүгээр сарын дундаж агаарын Өргөн, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад 14.2-15.0 хэм дулаан, бусад сумдын нутгаар 11.8-13.7 хэм дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө 26-30 хэм байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Эрдэнэ, Өргөн, Улаанбадрах, Сайхандулаан сумдад олон жилийн дунджаас 1.1-2.2 градусаар хүйтэн, Иххэт суманд ОЖД-аас 1.1 градусаар дулаан, бусад сумдын нутгаар ОЖД-ийн орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 0-4 хэм хүйтэн, өдөртөө 45-50 хэм дулаан байв.

9 дүгээр сард нийт нутгаар 2-10 өдөр бороо орлоо. Сарын нийлбэр хамгийн их бороо Дэлгэрэх суманд 51.8 мм, бусад сумдын нутгаар 9.7-27.8 мм бороо орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг ОЖД-тай харьцуулахад: Мандах, Сайхандулаан, Эрдэнэ, Дэлгэрэх, Айраг, Иххэт сумдад ОЖД-аас ахиу, бусад сумдын нутгаар ОЖД-ийн орчим байв.

Энэ сард салхины хамгийн их хурд Улаанбадрах, Хатанбулаг сумдад 10-12 м/с хүрч, Сайншанд суманд 26 м/с, Хөвсгөл, Замын-Үүд, Эрдэнэ, Дэлгэрэх сумдад 21-24 м/с, бусад сумдын нутгаар 16-18 м/с хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна. 10м/с-ээс дээш салхитай хоногийн тоо Улаанбадрах суманд 1, Хатанбулаг суманд 4, Айраг, Иххэт, Өргөн сумдад 9, бусад сумдын нутгаар 11-20 өдөр байлаа.



## АГУУЛГА

### II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

- Нэг. Эрүүл мэнд
  - 1.1 Эрүүл мэнд
  - 1.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
  - 1.3 Халдварт өвчний гаргалт, сумаар
- Хоёр. Соёл, боловсрол
  - 2.1 Соёлын үзүүлэлтүүд
- Гурав. Хөдөлмөр эрхлэлт
  - 3.1 Ажилгүй иргэдийн тоо, боловсролын түвшингээр
  - 3.2 Ажилгүй иргэдийн тоо, сумаар
  - 3.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
  - 3.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
  - 3.5 Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
  - 3.6 Шинэ ажлын байранд орсон иргэн, эдийн засгийн салбарын ангиллаар
- Дөрөв. Нийгмийн даатгал, халамж
  - 4.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
  - 4.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
  - 4.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ
- Тав. Гэмт хэрэг
  - 5.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
  - 5.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар
- Зургаа. Мөнгө, зээл
  - 6.1 Мөнгөн гүйлгээ, зээл
  - 6.2 Хадгаламж, зээл, сумаар, сарын эцэст
- Долоо. Орон нутгийн төсөв
  - 7.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
  - 7.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
  - 7.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
  - 7.4. Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр
- Найм. Үнэ
  - 8.1 Хэрэглээний үнийн индекс
  - 8.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
  - 8.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар
- Ес. Хөдөө аж ахуй
  - 9.1 Мал төллөлт, төл бойжилт
  - 9.2 Том малын зүй бус хорогдол
  - 9.3 ХАА-н бүтээгдэхүүний үнийн судалгаа, төрлөөр
  - 9.4 Малын үнийн судалгаа, сумаар
- Арав. Аж үйлдвэр
  - 10.1 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
  - 10.2 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
  - 10.3 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
  - 10.4 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр
- Арван нэг. Барилга угсралт, орон сууц, нийтийн аж ахуй
  - 11.1 Барилга угсралт, их засварын ажил, төрлөөр, оны эцэст
  - 11.2 Барилга угсралт их засварын ажил, объектээр
- Арван хоёр. Тээвэр
  - 12.1 Тээвэр
  - 12.2 Нефть хангамж
- Арван гурав. Байгаль орчин
  - 13.1 Цаг уурын үзүүлэлт
- Тэмдэглэлийн тайлбар:
  - ( ... ) - тухайн тоо, баримт байхгүй
  - ( 0 ) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
  - ( x ) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
  - ( . ) - мэдээлэгдэх хугацаа болоогүй



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
( 2018 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН БАЙДЛААР )

**I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2015	2016	2017	2018	2018 - 2017	2018 2017
1. Бэлэн хүн ам	мянган хүн	63.1	66.6	68.2	68.9	0.7	101.0
- Төрсөн хүүхдийн тоо*	тоо	1194	1083	954	1037	83	108.7
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	232	263	254	298	44	117.3
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	962	820	700	739	39	105.6
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	10	11	9	13	4	144.4
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	8.4	10.2	9.4	12.5	3.1	132.9
2. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	661	1510	566	533	-33	94.2
- 10000 хүнд ногдох	тоо	104.7	227	84	78	-6	93.1
3. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 087	996	1 555	965	- 590	62.1
- Үүнээс эмэгтэй	тоо	650	519	785	468	- 317	59.6
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	266	389	366	236	-148	64.4
4. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	725	286	363	270	-93	74.4
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	725	174	351	142	-209	40.5
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	112	12	128	116	
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	424	490	534	396	-138	74.2
- 10000 хүнд ногдох ***	тоо	102	115	124	92	-33	73.7
6.Бойжиж буй төл, мян толгой	толгой	532414	469517	586705	604177	17472	103.0
- Ботго	толгой	6048	6005	6668	6552	-116	98.3
- Унага	толгой	19901	12817	21649	21757	108	100.5
- Тугал	толгой	17496	12753	16615	17910	1295	107.8
- Хурга	толгой	250294	236632	286903	298453	11550	104.0
- Ишиг	толгой	238675	201310	254870	259505	4635	101.8
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	6681.8	11011.9	110757.5	159948.5	49191.0	144.4
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	6365.4	7151.3	175331.9	231302.1	55970.2	131.9

\* - 2015, 2016, 2017 оны жилийн эцэст

\*\*-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

\*\*\* - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



## II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

## НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

## 1.1. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн эхний 09 сарын эцэст

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 I-IX	2018 I-IX	Өсөлт	
		Тоо		Хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	255.4	263.4	8.0	103.1
2. Ор хоног	мян.хүн	85.4	89.9	4.5	105.3
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	8.7	8.4	-0.3	96.6
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	12.0	12.5	0.5	104.2
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	13.9	14.8	0.9	106.5
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.4	2.5	0.1	104.2
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	2045	2406	361	117.7
Үүнээс: нас баралт	хүн	62	76	14	122.6
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1171	1207	36	103.1
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1014	1062	48	104.7
8. Амаржсан эх	хүн	948	1034	86	109.1
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	1	4	3	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	9	13	4	144.4

## 1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн эхний 09 сарын эцэст

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
	Тоо				
Дүн	1034	0	1037	13	4
Айраг					
Алтанширээ	1				
Даланжаргалан					
Дэлгэрэх	1		1		
Иххэт	1		1		
Мандах					
Өргөн					
Сайхандулаан					
Улаанбадрах				1	
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	1		1		1
Эрдэнэ	4		4	1	
Сайншанд	832		834	7	1
Замын - Үүд	193		195	4	2

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



## 1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн эхний 09 сарын эцэст

Үзүүлэлт	2017 I-IX	2018 I-IX	Өсөлт	
	тоо		тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	566	533	-33	94.2
Вируст гепатит	8	7	-1	87.5
Сүрьеэ	68	76	8	111.8
Тэмбүү	71	89	18	125.4
Заг хүйтэн	96	147	51	153.1
Трихоминиаз	58	66	8	113.8
Цусан суулга	32	51	19	159.4
Бусад	233	97	-136	41.6

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар

## ХОЁР. СОЁЛ

## 2.1 СОЁЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Хэмжих нэгж	2017 I-IX	2018 I-IX	Өсөлт	
				тоо	хувь
1. Театр -тоглолт	тоо	100	138	38	138.0
- шинэ уран бүтээл	тоо	0	4	4	0.0
- үзэгчид	мян.хүн	24.4	26.9	2.5	110.2
- орлого	мян.төг	27 983.9	22 781.5	-5 202.4	81.4
- хамрагдсан ААН	тоо	1	1	0.0	0.0
2. Музей					
- үзэгчид	мян. хүн	3.9	3.5	-0.4	89.7
- орлого	мян.төг	3 492.3	4 220.0	727.7	120.8
- хамрагдсан ААН	тоо	2	2	0	0.0



## ГУРАВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

## 3.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 09 сарын эцэст

Боловсролын түвшингээр	2015. IX	2016.IX	2017.IX	2018. IX	$\frac{2018. IX}{2015. IX}$	$\frac{2018. IX}{2017.IX}$
	хүний тоо				хувь	
ДҮН	1 087	996	1 555	965	88.8	62.1
Үүнээс: Эмэгтэй	650	519	785	468	72.0	59.6
Магистр, доктор	6	7	9	2	33.3	22.2
Дээд боловсролтой	283	263	361	161	56.9	44.6
Тусгай дунд	134	107	122	33	24.6	27.0
Техник мэргэжлийн	116	113	144	64	55.2	44.4
Бүрэн дунд	382	362	758	624	163.4	82.3
Бүрэн бус дунд	129	115	123	49	38.0	39.8
Бага	29	21	19	8	27.6	42.1
Боловсролгүй	8	8	19	24	300.0	2.2 <sup>2</sup>

## 3.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 09 сарын эцэст

	Ажилгүй иргэдийн тоо		Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
	2017. IX	2018. IX	2017. IX	2018.IX	2017. IX	2018.IX
ДҮН	1555	965	436	443	735	2201
Айраг	97	19	47	31	48	137
Алтанширээ	19	36	8	10	6	93
Даланжаргалан	63	71	53	37	49	135
Дэлгэрэх	27	16	14	4	13	22
Иххэт	30	29	2	29	14	278
Мандах	25	17	15	71	50	105
Өргөн	49	24	23	26	64	107
Сайхандулаан	15	11	7	5	40	677
Улаанбадрах	29	17	52	46	50	39
Хатанбулаг	45	19	5	18	42	94
Хөвсгөл	15	7	15	16	31	62
Эрдэнэ	29	30	9	9	15	30
Сайншанд	807	526	142	98	231	304
Замын - Үүд	305	143	44	43	82	118

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 3.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 09 сарын эцэст

Салбарын ангилал	2017.IX	2018.IX
	Тоо	
Бүгд	593	539
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	12	10
Уул уурхай олборлох аж үйлдвэр	350	194
Боловсруулах үйлдвэрлэл	9	7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	6	6
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	3	9
Барилга	1	61
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	1	1
Тээвэр агуулахын үйл ажиллагаа		17
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ		1
Мэдээлэл, холбоо	1	
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	7	15
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа		
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа		
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	5	3
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	49	57
Боловсрол	33	33
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	22	30
Урлаг, үзвэр,тоглоом наадам	7	11
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	87	83
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ		
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа		1

## 3.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 09 сарын эцэст

Үзүүлэлт	2017. IX	2018. IX
	Тоо	
Бүгд	593	539
Менежер	9	11
Мэргэжилтэн	112	117
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	93	62
Контор, үйлчилгээний ажилтан	22	19
Худалдаа, үйлчилгээний ажилтан	75	55
ХАА, ой загас агнуурын ажилтан	2	3
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний ажилтан	71	32
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, үгсрагч	101	78
Энгийн ажил мэргэжил	101	150
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	7	12

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



## 3.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 09 сарын эцэст

Үзүүлэлт	2017. IX		2018. IX	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо			
Бүгд	436	181	443	195
Менежер	9	2	10	7
Мэргэжилтэн	58	46	74	52
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	77	38	45	25
Контор, үйлчилгээний ажилтан	17	14	22	15
Худалдаа, үйлчилгээний ажилтан	61	47	51	39
ХАА, ой загас агнуурын ажилтан	1	0	1	
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	45	6	27	6
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	78	6	62	11
Энгийн ажил мэргэжил	84	21	140	36
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	6	1	11	4

## 3.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар, 09 сарын эцэст

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар	
			Байнга	Улирал
	тоо			
Бүгд	270	84	142	128
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	2		2	
Уул уурхай олборлолт	92	18	73	19
Боловсруулах үйлдвэрлэл	10	6	2	8
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж				
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент				
Барилга	45	10	34	11
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	30	9	14	16
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	31	12	1	30
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	16	13		16
Мэдээлэл холбоо				
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1		1	
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	10	2	5	5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа				
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	26	8	3	23
Боловсрол	1	1	1	
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	5	5	5	
Урлаг үзвэр тоглоом наадам				
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1		1	
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ДӨРӨВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

4.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр, жил бүрийн 09 сарын эцэст

	Олгосон тэтгэвэр тэтгэмж		<u>2018 I-IX</u>
	2017 I-IX	2018 I-IX	2017 I-IX
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	20 474.3	23 799.1	116.2
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	12 246.9	14 974.3	122.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 387.9	1 697.9	122.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	4 252.5	3 956.5	93.0
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	2 026.6	2 482.2	122.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	560.4	688.2	122.8
Нийгмийн даатгалын сангийн зарлага	29 144.9	33303.6	114.3
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	20 683.3	24 203.9	117.0
Тэтгэмжийн даатгалын сангийн	1 566.2	1 873.6	119.6
Эрүүл мэндийн даатгалын сангийн	4 566.5	4 809.7	105.3
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	1 641.8	1 813.4	110.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	687.1	603.0	87.8

\*\* - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

4.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 09 сарын эцэст

Үзүүлэлт	ХЭМЖИХ НЭГЖ	2017 I-IX	2018 I-IX	<u>2018 I-IX</u> 2017 I-IX
1. Заавал даатгуулагч хүний тоо	тоо	16229	17009	104.8
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	тоо	7944	8740	110.0
Төсөвт байгууллага	тоо	8285	8269	99.8
2. Олгосон тэтгэвэр	сая төгрөг	21282.0	24818.1	116.6
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	сая төгрөг	15602.3	18017.0	115.5
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	сая төгрөг	2338.0	2807.2	120.1
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	сая төгрөг	1077.6	1232.2	114.3
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	сая төгрөг	638.2	651.5	102.1
Цэргийн тэтгэвэр	сая төгрөг	1625.9	2110.2	129.8

Эх үүсвэр: Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс



4.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 09 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2018 I- IX	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2018 I- IX
	2017 I-IX	2018 I-IX	2017 I- IX	2017 I- IX	2018 I-IX	2017 I- IX
	тоо		хувь	мянган төгрөг		хувь
<b>НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ</b>	<b>17576</b>	<b>22998</b>	<b>130.8</b>	<b>4498142.9</b>	<b>6069971.0</b>	<b>134.9</b>
<b>1. Халамжийн тэтгэвэр</b>	<b>1373</b>	<b>1362</b>	<b>99.2</b>	<b>1620515.3</b>	<b>1703269.2</b>	<b>105.1</b>
Ахмад настны тэтгэвэр	60	60	100.0	72010.4	75063.4	104.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1313	1302	99.2	1548504.9	1628205.8	105.1
<b>2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж</b>	<b>1181</b>	<b>1069</b>	<b>90.5</b>	<b>577292.3</b>	<b>568733.1</b>	<b>98.5</b>
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	1100	1006	91.5	537103.7	532350.8	99.1
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	53	51	96.2	30055.4	30298.1	100.8
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	6	85.7	3567.0	4341.3	121.7
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	12	5	41.7	4524.6	1678.9	37.1
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн	9	1	11.1	2041.6	64.0	3.1
<b>3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн</b>	<b>998</b>	<b>996</b>	<b>99.8</b>	<b>457093.1</b>	<b>466134.9</b>	<b>102.0</b>
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	362	234	64.6	277928.4	287914.9	103.6
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	595	711	119.5	164764.7	112260.0	68.1
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/	37	4	10.8	3600.0	360.0	10.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	1	10	9 <sup>2</sup>	6000.0	20000.0	2.3 <sup>2</sup>
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	2	11	4.5 <sup>2</sup>	2400.0	13200.0	4.5 <sup>2</sup>
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	1	14	13.0 <sup>2</sup>	2400.0	18000.0	6.5 <sup>2</sup>
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн		12			14400.0	
<b>4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал</b>						
<b>5. Нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал</b>	<b>7082</b>	<b>8386</b>	<b>118.4</b>	<b>819523.5</b>	<b>823038.1</b>	<b>100.4</b>
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	4313	3847	89.2	264110.7	265194.9	100.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	274	286	104.4	63604.2	74046.7	116.4
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил					5125.3	
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт		2896			289051.0	
Банкны шимтгэл					3047.8	
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	2495	1357	54.4	491808.6	186572.4	37.9
<b>6. Бусад хамалжийн дүн</b>	<b>6942</b>	<b>11185</b>	<b>161.1</b>	<b>1023718.7</b>	<b>2508795.7</b>	<b>245.1</b>
Алдарт эхийн одонгийн тусламж	4723	4865	103.0	642020.0	650860.0	101.4
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	15	18	120.0	18798.7	26954.2	143.4
Цалинтай ээж хөтөлбөр		3769			1342412.5	
Өрх толгойлсон эх/эцэг хөтөлбөрийн зардал		155			111129.0	
Насны хишгийн зардал	2204	2378	107.9	362900.0	377440.0	104.0



ТАВ. ГЭМТ ХЭРЭГ

5.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО, төрлөөр, жил бүрийн 09 сарын эцэст

Хэргийн төрөл	2017 I-IX	2018 I-IX	зөрүү	Хэргийн бүтэц	
				2017	2018
	тоо	хувь			
<b>Бүртгэгдсэн гэмт хэрэг - ДҮН</b>	534	396	-138	100.0	100.0
Хүн амины гэмт хэрэг	19	5	-14	3.6	1.3
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	15	14	-1	2.8	3.5
Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг	129	101	-28	24.2	25.5
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	226	172	-54	42.3	43.4
Хулгайлах	131	83	-48	24.5	21.0
Залилах	23	26	3	4.3	6.6
Гээгдэл эд зүйл ашиглах	14	11	-3	2.6	2.8
Хөрөнгө завших	14	12	-2	2.6	3.0
Бусдын эд хөрөнгө устгах, гэмтээх, үүнээс: үрэгдүүлэх /17.11/	1	1	0	0.2	0.3
Эд хөрөнгө устгах, гэмтээх	8	6	-2	1.5	1.5
Дээрэмдэх	4	6	2	0.7	1.5
Авто тээврийн хэрэгслийг зөвшөөрөлгүйгээр авч явах	1	1	0	0.2	0.3
Мал хулгайлах	30	26	-4	5.6	6.6
Улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн	43	20	-23	8.1	5.1
Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	3	16	13	0.6	4.0
Авилгын гэмт хэрэг	3		-3	0.6	0.0
